

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

/Цахим/

2020.05.07

1. Иргэний нисэхийн ерөнхий газар нь **“Дорнод аймгийн “Чойбалсан” нисэх буудлыг 4С ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадал бүхий нисэх буудал болгох, өргөтгөх зураг, төсөл боловсруулах”** ажлыг хийж, гүйцэтгэхтэй холбоотойгоор зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь **“Дорнод аймгийн “Чойбалсан” нисэх буудлыг 4С ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадал бүхий нисэх буудал болгох, өргөтгөх зураг, төсөл боловсруулах” ажлыг хийж, гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай болно. ИНЕГ/ХОӨ/ТББ/Б-01/20**

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг Монгол улсын **“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлийг хангасныг нотлох мэдээллүүд.**

- Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар ирүүлэх
- Татварын өргүй тухай татварын албаны цахим тодорхойлолт ирүүлэх
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлэх
- Шүүхийн тамгын газрын тодорхойлолт ирүүлэх
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх
- Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээлийн өр, төлбөргүй эсэх тодорхойлолт ирүүлэх
- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн (2018, 2019 он) борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.
- Сүүлийн 2 жилийн (2018, 2019 оны) аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ
- Сүүлийн 1 жилийн (2019 оны) санхүүгийн тайлангаар ашигтай ажилласан байх шаардлагатай
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгөө нотлож ирүүлэх эсхүл авч болох зээлийн хэмжээ төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.
- Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх удирдах, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадварын талаарх мэдээллийг ирүүлэх
- Шаардлагатай тусгай зөвшөөрөл: Нисэх буудлын хөөрч буух зурвасын зураг төсөл боловсруулах 2.8.1.6 заалтын дагуу тусгай зөвшөөрөлтэй байх.

Нэмэлт мэдээллийг **2020 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 17 цаг 00 минут** хүртэл авч болно.

Зөвлөхийн мэдүүлгээ дор дурдсан хаягаар **2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 10 цаг 00 минут** дотор Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn цахим системээр ирүүлнэ үү.

***Улаанбаатар хот, Буянт-Ухаа, Иргэний нисэхийн ерөнхий газар,
Худалдан авах ажиллагааны тасаг 108 тоот өрөө. Утас 71282037***